

ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ-2025 БАГА СУНГАА СОРИЛ

Хувилбар В

1. Дунд палеолитын үед гарсан дэвшил аль нь вэ? (1 оноо)
А. Эхийн эрхт овог В. Гал
С. Хэл яриа D. Үйлдвэрлэх аж ахуй E. Хүрэл зэвсэг
2. Мезолитын үед багаж зэвсэгт ямар дэвшил гарсан бэ? (2 оноо)
А. Зэсийг хорголжин тугалгатай хольж хүрэл боловсруулж эхэлсэн.
В. Үлдэц, цуулдас гаргах аргаар чулуун зэвсэг хийх болсон.
С. Модны уян харимхай чанарыг ашиглан нум сум зохион бүтээсэн.
D. Шавар ваар, сав хийж хэрэглэх болсон.
E. Үзүүр мэсийг ишинд бэхэлж жад хийх болсон.
3. 3000 гаруй сувс, хүний нүүр сийлсэн чулуун онго, чулуун ир шигтгэсэн ясан хутга, амьтны шүд хэлхсэн хүзүүний зүүлт, ясан бугуйвч зэрэг гоёлын зүйлс болон чулуун зэвсгүүд дагалдуулсан неолитын үеийн булш хаанаас олдсон бэ? (1 оноо)
А. Ховд аймгийн Манхан сумын Хойд цэнхэрийн агуй
В. Өвөрхангай аймгийн Хархорин сумын Мойлтын ам
С. Дундговь аймгийн Гурвансайхан сумын Ярх уул
D. Дорнод аймгийн Булган сумын Норовлин
E. Баянхонгор аймгийн Баянлиг сумын Цагаан агуй
4. Цэгийн оронд тохирох утгыг нөхөж бичнэ үү.
Монгол орны зүүн, төв нутгаар голлон тархсан хүрэл, түрүү төмрийн үеийн оршуулгын байгууламжийг гэнэ. (1 оноо)
А. Чемуручекийн соёл В. Буган хөшөө
С. Хадны зураг D. Хиргисүүр E. Дөрвөлжин булш
5. Хүрлийн үе, түрүү төмрийн үеэс цэргийн удирдагчдын гарт эрх мэдэл очив. Цэргийн удирдагчдад эрх мэдэл төвлөрөх болсон шалтгааныг тодорхойлно уу. (1 оноо)
А. Торгоны замд нөлөөллөө тогтоох өрсөлдөөн нэмэгдсэн.
В. Галыг эзэмшсэн нь цэргийн удирдагчдад давуу байдлыг үүсгэсэн.
С. Нум сум зохион бүтээснээр эрчүүд илүү эрх мэдэлтэй болсон.
D. Овог аймгуудын хооронд зөрчил тэмцэл гарах болсноор цэргийн үүрэг нэмэгдсэн.
E. Овог дотор өмч хөрөнгийн ялгаа бий болсноор тэдний зарим хэсэг нь эрх мэдэлтэй болсон.
6. Хүннү гүрний түүхэнд холбогдох үйл явдлуудыг онтой нь зөв харгалзуулна уу. (1 оноо)
1. Хүннү гүрэн байгуулагдав. a. НТ 93 он
2. Хүннү гүрэн умард, өмнөд хоёр хэсэгт хуваагдав. b. НТӨ 209 он
3. Хүннү гүрэн мөхөв. c. НТ 48 он
- A. 1c2a3b B. 1a2b3c C. 1b2c3a D. 1b2a3c E. 1c2b3a
7. Даюанаас баруун тийш 3000 ли /1500км/ газар Гүй голын хойно Их Юэжи нар амьдардаг. 1 ли хэдэн км-тэй тэнцэх вэ? (2 оноо)
A. 0.5 км B. 1500 км C. 4500 км D. 2 км E. 0.05 км
8. Монгол нутагт оршиж байсан Түрэг угсааны улсыг олно уу. (1 оноо)
A. Уйгур улс В. Сяньби улс
C. Хүннү улс D. Жужан улс E. Хятан улс

9. "Их ахлагч нум сум, эмээл хазаар хийж чаддаг, алт, төмөр хайлдаг, цэргийн зэвсэг хийдэг, арьс боловсруулдаг..." гэсэн сурвалжийн мэдээ нь ямар аж ахуйн талаар өгүүлж байна вэ? (1 оноо)

- A. Худалдаа, арилжаа В. Газар тариалан
C. Мал аж ахуй D. Ан гөрөө E. Гар урлал

10. "Хань (Хятад)-ийн торго дурданг өвс бутан дундуур чирэн явав. Хувцас хунар цөм урагдан салбарчээ. Арьсан дээл хувцас шиг бөх биш юм. Хань-ийн хоол идээ бүгдийг хаяв. Айраг хурууд шиг шимтэй бус гэдгийг үзэв" гэсэн сурвалжийн мэдээ нь ямар утга санаа илэрхийлж байна вэ? (1 оноо)

- A. Хүннүчүүд бүх дээл хувцсаа торгоор хийдэг байсан.
В. Хань улсын хоол хүнс, эдийн соёл нь Хүннүгийнхээс илүү зохимжтой байсан.
С. Хүннү нар Хань улстай хувцас хунар, хоол, идээ ижил байсан.
D. Хүннү улсын хоол хүнс, эдийн соёл нь Хань улсынхаас илүү зохимжтой байсан.
E. Хань улс Хүннү нартай адил айраг хурууд хүнсэндээ хэрэглэх болсон.

11. Хятан гүрний хаад ямар шашныг тэтгэж байсан бэ? (1 оноо)

- A. Исламын шашин В. Бөөгийн шашин
C. Бурхны шашин D. Загалмайн шашин E. Манихейн шашин

12. Хүннүгийн язгууртны булшнаас /Архангай аймгийн Өндөр-Улаан сум/ Ромын шилэн аяга олдсон нь юуг илэрхийлж байна вэ? (1 оноо)

- A. Хүннү гүрэн, Ромын эзэнт улсыг эзлэн захирч байсан.
В. Хүннү гүрэн өрнийн орнуудтай худалдаа, эдийн засгийн харилцаатай байсан.
С. Хүннү гүрэн, Ромын эзэнт улстай шууд хиллэдэг байсан.
D. Ромын шилэн аяга Хүннү нараас үүсэлтэй
E. Хүннү гүрний шаньюй, Ромын эзэнт гүрэнд айлчилж байсан.

13. Монголын Хэрэйд, Найман зэрэг улсууд нь ямар шашин шүтэж байсан бэ? (1 оноо)

- A. Бөөгийн шашин В. Загалмайн шашин
C. Исламын шашин D. Буддын шашин E. Манихейн шашин

14. 1130 онд Хабул хан Монгол улсыг байгуулжээ. Энэ үйл явдал хэддүгээр зуунд хамаарахыг тооцоолно уу. (2 оноо)

- A. X зууны I хагас В. XII зууны II хагас
C. XI зууны I хагас D. XII зууны I хагас E. XI зууны II хагас

15. "Татар хүний бие бялдар өндөр бус, хамгийн өндөр нь таван тохой хоёр ямхаас давахгүй" гэсэн сурвалжийн мэдээг ашиглан татар хүний өндрийг тооцоолон олно уу. /нэг тохой 35 см орчим, ямх-3.2 см/ (2 оноо)

- A. 156.4 см B. 175 см C. 176.4 см D. 171.4 см E. 181.4 см

16. Их Монгол улс 1260-1264 онд нэгэн зэрэг хоёр хаантай байсан. Тэдгээр хаадыг олно уу. (1 оноо)

- A. Хубилай, Аригбөх В. Гүюг, Мөнх
C. Өгэдэй, Тулуй D. Хубилай, Хайду E. Хүлэгү, Аригбөх

17. Юань улс хүн амаа дөрвөн зэрэгт хуваажээ. Монгол хүн хэддүгээр зэрэгт хамаарах вэ? (1 оноо)

- A. Гуравдугаар B. Дэд C. Дөрөвдүгээр D. Тэргүүн E. Тавдугаар

18. Цагадайн улсын газар нутгийг зөв тодорхойлно уу. (1 оноо)
 А. Өнөөгийн Иран, Ирак, Азербайжан, Армян, Гүрж, Турк, Афганистаны баруун хэсэг Сирийн хойд хэсэг
 В. Дорно зүг Эрчис мөрөн, өрнө зүг Дунай мөрний доод урсгал, өмнө зүг Кавказын нуруу, хойд зүгт Ижил мөрөн хүртэл
 С. Или голын сав, Долоон гол, Кашгарын нутаг буюу хуучин Хар Хятаны нутаг
 D. Монгол, Төвөд, Солонгос, Хятадын нутаг
 E. Өнөөгийн Иран, Ирак, Солонгос, Хятадын нутаг

19. Даалгаврыг гүйцэтгэхдээ дараах томъёог ашиглаарай. ($X=M-M/33+622$)
 Хижрийн 719 онд Бухар хотод цутгасан зоосны нүүрэн талд "Кебек хаан" ар талд "Цагадай хааны тамга" сийлжээ. Хижрийн тооллын 719 оныг аргын тоололд шилжүүлнэ үү. (2 оноо)
 А. 64 он В. 655 он С. 1374 он D. 1341 он E. 1320 он

20. Төгстөмөр хааны төр барьсан он аль нь вэ? (1 оноо)
 А. 1400-1402 он В. 1370-1378 он
 С. 1393-1399 он D. 1378-1388 он E. 1403-1412 он

21. Улс төрийн бутралын үеийн Зүүн Монголын баруун гарын гурван түмнийг зөв ялгасныг олно уу (2 оноо)
 1. Ордос 2. Халх 3. Урианхай 4. Түмэд 5. Юншээбүү 6. Цахар
 А. 1,4,5 В. 2,3,6 С. 2,4,5 D. 1,2,3 E. 1,3,6

22. Мин улс Монголчуудтай худалдаа хийхдээ баримталдаг "адуун засгийн бодлого" нь ямар зорилготой байсан бэ? (2 оноо)
 А. Худалдааны салбарт адуу ашиглан бараа таваар тээвэрлэх
 В. Газар тариалангийн салбарт адууны хүчийг ихээр ашиглах
 С. Монголчуудын цэрэглэх чадварыг бууруулах, адуун сүргийн бүтцийг алдагдуулах
 D. Мин улс барууны улс орнуудтай адуугаар худалдаа хийх
 E. Монголчуудад адуугаараа хятад бараа худалдан авах нь ашигтай байсан

23. Зүүнгарын хаант улсыг байгуулсан түүхэн зүтгэлтэн аль нь вэ? (1 оноо)
 А. Гүүш хан Төрбайх В. Галдан хаан
 С. Цэвээнравдан хаан D. Галданцэрэн хаан E. Даваач хаан

24. Тод үсгийг хэн зохиосон бэ? (1 оноо)
 А. Пагва лам В. Өндөр гэгээн Занабазар
 С. Аюуш гүүш D. Зая бандида Намхайжамц E. Агваан лам

25. Түмэдийн Алтан ханы шашны цааз ёсоор лам нарт юуг хориглож байсан бэ? (2 оноо)
 А. Тойн лам нар гэргий авахыг хориглоно.
 В. Сүм, хийдэд ерөөл, хурал майдар эргэхийг хориглоно.
 С. Сарын гурван бацгийн (мацаг) өдөр мацаг барихыг хориглоно.
 D. Төвөд хэл бичиг сурахыг хориглоно.
 E. Хүрээ хийдэд шавилан суухыг хориглоно.

26. Монголд бурхны шашин дэлгэрэхэд нөлөөлсөн гадаад хүчин зүйл аль нь вэ? (2 оноо)
 А. Шашин дэлгэрэхэд улсаас эдийн засгийн дэмжлэг үзүүлсэн.
 В. Монголын эрх баригчид улс орныхоо нэгдмэл байдлыг сэргээн бэхжүүлэх зорилготой байсан.
 С. Бөөгийн хойлголох ёсыг халж хүн нас барахад амьтны амь таслахыг хориглосон нь ард олны сэтгэлд нийцсэн.
 D. Шашны цаазаар лам нарын эрх, дархыг хуульчлан баталж, дэмжих бодлого явуулсан.
 E. Монголчуудыг шашиндаа оруулснаар нөлөөнийхөө хүрээг тэлэх, Төв Азид өөрийн улсын эзлэх байр суурийг өсгөх зорилготой байсан.

27. Халх Монгол Манжид хэзээ дагаар орсон бэ? (1 оноо)
 А. 1755 он В. 1636 он С. 1721 он D. 1691 он E. 1688 он

28. 1636 оны Мүгдэнгийн чуулганаар Өвөр Монголын ноёд ямар асуудлыг шийдвэрлэсэн бэ? (2 оноо)
 А. Түшээт хан Гомбодоржийн хүү Занабазарыг Халхын шарын шашны тэргүүнээр өргөмжлөв.
 В. Халхын ноёд Манжид дагаар орох асуудлыг хэлэлцэв.
 С. Өвөр Монголын 16 аймгийн ноёд Манж улсын хааныг эзэн хаанаа хэмээн зөвшөөрөв
 D. "Монгол-Ойрадын Их цааз" -ыг батлав.
 E. Торгуудын Хо өрлөг, Дөрвөдийн Далай тайш нар харьяатаа авч баруун тийш нүүдэллэв.

29. 1630-аад оны дундуур Ижил мөрний доод хэсэгт нутаглах болсон Монголчуудыг хожим юу гэж нэрлэх болсон бэ? (1 оноо)
 А. Буриад Монгол В. Халимаг
 С. Өвөр Монгол D. Хазар E. Аварууд

30. 1617 онд Авга хар ууланд Очир Цагаан хотыг хэн байгуулсан бэ? (1 оноо)
 А. Хубилай хаан В. Алтан хан
 С. Өндөр гэгээн Занабазар D. Лигдэн хаан E. Цогт тайж

31. Монголчууд харийн эрхшээлд ороход нөлөөлсөн гадаад шалтгааныг олно уу. (2 оноо)
 А. Монголын их хааны засаглал суларсан.
 В. Халхын баруун, зүүн гар хоорондоо дайсагнасан байдалтай байсан.
 С. Зүүнгар улс болон Халх Монгол хоорондоо эв түнжингүй байсан.
 D. Монголчууд Мин улстай худалдаа арилжаа хийж байсан.
 E. Манж нар хагалан бутаргах, эзлэн түрэмгийлэх бодлого явуулсан.

32. Цэгийн оронд тохирох утгыг нөхөж бичнэ үү.
 Ихэтуаны бослогыг даруулахаар Халх Монголоос татсан 2000 монгол цэрэг 1900 онд Улиастайд удирдлагаар бослого дэгдэв. (1 оноо)
 А. Энхтайван В. Цогдалай С. Чингүнжав
 D. Онолт E. Тогтох тайж

33. Өвөр Монголд XIX зууны дунд үеэс манжийн эсрэг бослого тэмцэл удаа дараа гарах болсон шалтгаан аль нь вэ? (2 оноо)
 А. 1758 оны эцэс хүртэл Зүүнгарын босогчид хэсэг бүлгээр тулалдсанаас болсон.
 В. Шинэ засгийн бодлого хэрэгжиж эхэлсэн.
 С. 1756 онд Чин ван Эринчиндоржийг Амарсанаагийн хэрэгт холбогдуулан цаазаар авснаас болсон.
 D. Хятадын мөнгө хүүлэгч, худалдаачдын мөлжлөг, хятад иргэд нутаг бэлчээр булаан тариа тарин суурьших болсон.
 E. Халх Монголчуудаас авах манжийн алба нэмэгдсэнээс болсон.

34. Монголчууд Манжийн эрхшээлээс салж тусгаар тогтнолоо хэзээ сэргээн тунхагласан бэ? (1 оноо)
 A. 1911.12.01 B. 1911.11.30
 C. 1911.12.29 D. 1911.12.04 E. 1911.12.03
35. Монголчууд Ховдыг Манжийн эрхшээлээс хэзээ чөлөөлсөн бэ? (1 оноо)
 A. 1912.1 сард B. 1912.8 сард
 C. 1912.2 сард D. 1914.2 сард E. 1915.6 сард
36. Хужирбуланд цэргийн сургууль хэзээ байгуулсан бэ? (1 оноо)
 A. 1914 он B. 1913 он C. 1912 он D. 1915 он E. 1918 он
37. 1918 онд “Зарлигаар тогтоосон Монгол Улсын шаштир” хэмээх түүхийн бүтээл гарчээ. Энэ нь Олноо өргөгдсөний хэддүгээр он бэ? (2 оноо)
 A. 9 дугаар он B. 7 дугаар он
 C. 18 дугаар он D. 8 дугаар он E. 19 дугаар он
38. Ардын Түр Засгийн газрын үйл ажиллагаанд аль нь хамаарах вэ? (2 оноо)
 A. АТЗГ-тай сөргөлдөж байсан тул яваандаа зэвсэгт мөргөлдөөнд зайлшгүй хүрнэ хэмээн бэлтгэлээ хангаж байсан.
 B. “Бага болзоот” хэмээх цаасан мөнгө гаргасан.
 C. Гадаад бодлогодоо анхаарч Монгол, Дундад иргэн улсын хооронд АНУ-аар зуучлуулах хүсэлт гаргасан.
 D. Америкийн консулыг Монголд суулгах хүсэлт гаргасан.
 E. Цагаантны цэргийг хөөн зайлуулахын тулд улаан цэргийн ангийг Монголд оруулах хүсэлтийг ЗОУ-д тавьсан.
39. Монгол улсын хөгжлийн талаарх С.Данзангийн үзэл баримтлал аль нь вэ? (1 оноо)
 A. Монголд бүгд найрамдах засаг тогтоох, хүн төрлөхтний туулж ирсэн жам ёсны хөгжлийн дагуу, шат дараалан хөгжих ёстой
 B. Ардын эрхт, хэмжээт цаазат засаг тухайн цаг үед тохиромжтой
 C. Уламжлал, шинэчлэлийг хослуулах, ардчилсан чиг шугамыг баримтлах
 D. Монгол улс социалист чиг баримжаагаар хөгжих
 E. Уламжлалт хэмжээгүй эрхт хаант засаглалтай байх
40. Ардын засгийн газраас дотоод байдлаа бэхжүүлэхийн тулд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ аль нь вэ? (2 оноо)
 A. 1921 оны 11 сарын 5 нд ЗОУ-тай найрамдлын гэрээ байгуулсан
 B. Дэлхийн олон улсад хандан хэмжээт цаазат хаант Монгол улс байгуулагдсаныг зарлан мэдэгдсэн.
 C. С.Данзан тэргүүтэй Монголын төлөөлөгчид Москвад айлчилсан.
 D. Эзэн, хамжлагын харилцааг халах шийдвэр гаргасан.
 E. Дундад иргэн улс цэрэг-улс төрийн дарамт шахалт үзүүлж байсан үед ЗОУ-ыг түшиглэсэн.
41. Монгол улс бүгд найрамдах засаглалд хэзээ шилжсэн бэ? (1 оноо)
 A. 1924.06.07 B. 1940.06.30
 C. 1924.11.26 D. 1990.07.29 E. 1992.01.13
42. Анхдугаар Үндсэн хуулиар улс төрийн эрхээ хасуулсан хүмүүс аль нь вэ? (1 оноо)
 A. Малчид B. Жирийн ард C. Үгээгүй ядуу ард
 D. Бусдын хөдөлмөрийг үл мөлжигч 18 нас хүрсэн иргэн бүр
 E. Урьдын ван, гүн ба хутагт хувилгаад

43. Шинэ эргэлтийн бодлогын үр дүн аль нь вэ? (2 оноо)
 A. Төрөөс худалдааны салбарт тавих хяналтыг хүчтэй болгон хувийн худалдааг хавчих болсон.
 B. Ард иргэд хэвийн аж төрөх боломжгүй болсноос нутгаа орхин хил даван нүүж эхэлсэн
 C. Нөхөрлөл, коммуна, артель нэгдэл хэмээх дундын өмчтэй хоршоолол хэдэн зуугаар нь байгуулсан.
 D. Мал сүргийг өсгөх уян хатан бодлогын үр дүнд ганцхан жилийн дотор малын тоо 3.3 саяар өссөн.
 E. Улс орныг удирдах хэрэгт намын үүрэг нэмэгдсэн.
44. Дэлхийн II дайн ямар үйл явдлаар дууссан бэ? (1 оноо)
 A. 1945 оны 9 сарын 2-нд Япон үг дуугүй бууж өгөх актад гарын үсэг зурсан.
 B. 1945 оны 5 сарын 9-нд Нацист Герман бууж өгсөн.
 C. 1945 оны 8 сарын 9-нд ЗХУ, Японд дайн зарласан.
 D. 1945 оны 8 сарын 10-нд БНМАУ Японд дайн зарласан.
 E. 1945 оны 2 сард Ялтад гурван их гүрний уулзалт болсон.
45. Атрын анхдугаар аян хэдэн оноос эхэлсэн бэ? (1 оноо)
 A. 1961 он B. 1976 он C. 1959 он D. 1981 он E. 2008 он
46. Монголын урлаг, уран сайхны хөгжилд аль нь хамаарах вэ? (1 оноо)
 A. Монголын эрдэмтэд сансар судлалын “Интеркосмос” программыг хэрэгжүүлэх ажилд гар бие оролцсон.
 B. Сургуулийн бүтцийг 3+5+2 болгон өөрчилсөн.
 C. 1970 он гэхэд хүн амын 89,3% нь бичиг үсэг тайлагдсан.
 D. 1988 онд “Мандухай сэцэн хатан” кино дэлгэцнээ гарсан.
 E. Малын үүлдэр угсааг сайжруулах, элдэв өвчнийг анагаах чиглэлээр судалгаа хийсний үр дүнд Хангай, Байдраг зэрэг шинэ үүлдэр гаргасан.
47. БНМАУ 1972 онд Япон улстай дипломат харилцаа тогтоосон. Энэ жил дипломат харилцаа тогтоосны хэдэн жилийн ой вэ? (2 оноо)
 A. 51 жилийн ой B. 59 жилийн ой
 C. 57 жилийн ой D. 61 жилийн ой E. 50 жилийн ой
48. Дараах улсуудаас капиталист системд хамаарч байсныг олно уу. (2 оноо)
 A. Баруун Герман B. Зүүн Герман
 C. Чехословак D. Хятад E. Умард Солонгос
49. Монголын ардчилсан холбооны анхны улс төрийн цуглаан хэзээ болсон бэ? (1 оноо)
 A. 1989.12.07 B. 1990.02.18
 C. 1990.01.21 D. 1989.12.10 E. 1990.03.07
50. Аль түүхэн үйл явдлаар БНМАУ-д нэг намын ноёрхол эцэс болсон бэ? (2 оноо)
 A. 1990 оны 3 сарын 9-ний орой нам, төрийн тэргүүн Ж.Батмөнх ард түмэндээ хандан радио, телевизээр орон даяар мэдээлэл хийснээр
 B. 1990 оны 3 сарын 12-14 нд болсон МАХН-ын бүгд хурлаар УТТ, нарийн бичгийн дарга нарыг бүрэн бүрэлдэхүүнээр огцруулснаар
 C. 1990 оны 3 сарын 22-24-нд хуралдсан АИХ-ын чуулган, МАХН бол “төр нийгмийг удирдан чиглүүлэгч цорын ганц хүчин мөн” гэсэн үндсэн хуулийн заалтыг хүчингүй болгосноор
 D. 1990 оны 3 сарын 7-ны өдрийн 14 цагт МоАХ-ны 10 гишүүн Сүхбаатарын талбайд улс төрийн тэмцлийн хурц хэлбэр болох өлсгөлөн зарлан тэмцсэнээр
 E. 1990 оны 2 сарын 18-нд Монголын ардчилсан намыг эмхлэн байгуулснаар

51. Монгол улс 1992 онд шинэ Үндсэн хуулийг баталснаар ямар засаглалтай болсон бэ?

(1 оноо)

- A. Ерөнхийлөгчийн бүгд найрамдах засаглалтай болсон
- B. Парламентын бүгд найрамдах засаглалтай болсон
- C. Хэмжээгүй эрхт хаант засаглалтай болсон
- D. Хэмжээт эрхт хаант засаглалтай болсон
- E. Холимог бүгд найрамдах засаглалтай болсон

52. Шинэ үндсэн хуулиар гүйцэтгэх эрх мэдлийг төрийн ямар институт хэрэгжүүлэх болсон бэ?

(1 оноо)

- A. Үндсэн хуулийн цэц
- B. Улсын их хурал
- C. Улсын дээд шүүх
- D. Засгийн газар
- E. Ардын их хурал

53. 2012 оноос өвлийн тэргүүн сарын шинийн нэгний өдрийг ямар тэмдэглэлт баярын өдөр болгосон бэ?

(1 оноо)

- A. Олон улсын хүний эрхийн өдөр
- B. Эх орончдын өдөр
- C. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр
- D. Хэвлэлийн эрх чөлөөний өдөр
- E. Монгол бахархлын өдөр

54. Ардчилсан хувьсгалын үр дүнд үндэсний үзэл, ухамсар сэргэснийг илэрхийлэх баримт аль нь вэ?

(2 оноо)

- A. Төрт ёсны уламжлалт 9 хөлт цагаан тугаа хүндэтгэн залсан
- B. "Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль" баталсан
- C. 1993 онд Бурхан багшийн чандрыг Монголд залсан
- D. Спортын салбарт тив, дэлхийн аваргууд олноор төрсөн
- E. Электрон технологи бүтээж, цахим сүлжээ чөлөөтэй ашиглах болсон

55. АНУ, Япон, Европын холбоо, Энэтхэг, БНСУ, Турк зэрэг өрнө дорнын улсуудтай харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх нь ямар бодлого вэ?

(1 оноо)

- A. Олон улсын хамтын нийгэмлэгтэй харилцах бодлого
- B. Зөөлөн хүчний бодлого
- C. Социалист улсуудтай хамтын ажиллагаа гүнзгийрүүлэх бодлого
- D. "Гуравдагч хөрш"-ийн бодлого
- E. Европын улсуудтай харилцаагаа өргөжүүлэх бодлого

56. Цэгийн оронд тохирох утгыг нөхнө үү

Хүний эрх, эрх чөлөөг хангаж, үндсэн хуульт байгууллыг бататгаж, хууль дээдлэх ёс, Монгол төрийн залгамж чанар, үндэсний эв нэгдлийг сахин дээдэлж төрөө бэхжүүлж, улс төрийн тогтвортой байдлыг хангах нь.....-ын үндэс мөн.

(1 оноо)

- A. Хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал
- B. Хүний аюулгүй байдал
- C. Дотоод аюулгүй байдал
- D. Мэдээллийн аюулгүй байдал
- E. Эдийн засгийн аюулгүй байдал

ХОЁРДУГААР ХЭСЭГ

Санамж:

- a. Даалгаврын хариуг зөв тогтоож харгалзуулах, дараалал сэргээх байдлаар гүйцэтгэнэ үү.
- b. Зөв хариулт бүр нэг оноотой.

2.1. Монголын өвөг түүхийн үед холбогдох нээлт болон дурсгалуудыг хамрах үетэй нь зөв харгалзуулна уу.

(6 оноо)

- | | |
|---------------------------|---------------------------------|
| a. Жад | 1. Дээд палеолит |
| b. Амьтныг анх гаршуулсан | 2. Дунд палеолит |
| c. Овог үүссэн | 3. Хүрлийн үе, түрүү төмрийн үе |
| d. Үйлдвэрлэх аж ахуй | 4. Неолит |
| e. Цагаан агуй | 5. Доод палеолит |
| f. Дөрвөлжин булш | 6. Мезолит |

2.2. Чингис хаантай холбогдох үйл явдлуудыг он цагтай нь зөв харгалзуулна уу. (6 оноо)

- | | |
|---|------------|
| a. Чингис хаан Татарыг мөхөөв. | 1. 1206 он |
| b. Чингис хаан Наху гүний тулалдаанаар Найманыг мөхөөв. | 2. 1225 он |
| c. Их Монгол улсыг тунхаглан зарлав. | 3. 1202 он |
| d. Чингис хаан Алтан улсыг довтлов. | 4. 1227 он |
| e. Хорезм улсыг бүрэн эзлээд эх нутагтаа эргэж ирэв. | 5. 1211 он |
| f. Тангуд улсыг дайлж бүр мөсөн мөхөөв. | 6. 1204 он |

2.3. Түүхэн нэр томьёонуудыг зөв харгалзуулна уу. (6 оноо)

- | | |
|----------------------|----------------|
| a. Халх Монгол | 1. Торгууд |
| b. Өвөр Монгол | 2. Алчуболд |
| c. Өврийн таван отог | 3. Энх-Амгалан |
| d. Манж | 4. Шолой Уваш |
| e. Дөрвөн Ойрад | 5. Цахар |
| f. Хотгойд | 6. Түшээт хан |

2.4. Түүхэн үйл явдлын он цагийг тохируулахдаа 1-8 хүртэлх өгөгдлөөс сонгож харгалзуулна уу. /2 өгөгдөл илүү байгааг анхаарна уу/ (6 оноо)

- | | |
|---|-------------------------|
| a. Барон Унгерн Монголын зүүн хилээр орж ирэв. | 1. 1921 оны 7 сарын 10 |
| b. Зүүн хүрээ, Консулын дэнжийн 2 бүлэг хамтран хуралдав. | 2. 1921 оны 7 сарын 8 |
| c. Улаан цэрэг, Ардын журамт цэргийн хамт Хиагтыг чөлөөлөв. | 3. 1919 оны 11 сарын 17 |
| d. Барон Унгерн цэргээ авч Нийслэл хүрэнзэс гарав. | 4. 1920 оны 10 сарын 2 |
| e. Ардын журамт цэргийн гол хүч Нийслэл хүрээнд орж ирэв. | 5. 1921 оны 3 сарын 17 |
| f. Ардын засгийн газар байгуулагдав. | 6. 1921 оны 5 сард |
| | 7. 1921 оны 3 сарын 18 |
| | 8. 1921 оны 7 сарын 6 |

№	Зөв хариу	оноо
1	B	1
2	C	2
3	D	1
4	E	1
5	E	1
6	A	1
7	A	2
8	A	1
9	E	1
10	D	1
11	C	1
12	B	1
13	B	1
14	D	2
15	E	2
16	A	1
17	D	1
18	C	1
19	E	2
20	D	1
21	A	2
22	E	2
23	B	1
24	D	1
25	A	2
26	E	2
27	D	1
28	C	2
29	B	1
30	D	1

31	E	2
32	A	1
33	D	2
34	C	1
35	B	1
36	C	1
37	D	2
38	E	2
39	A	1
40	D	2
41	C	1
42	E	1
43	D	2
44	A	1
45	C	1
46	D	1
47	E	1
48	A	2
49	D	1
50	C	2
51	B	1
52	D	1
53	E	1
54	A	2
55	D	1
56	C	2

2.1	a2	1
	b1	1
	c3	1
	d4	1
	e5	1
	f6	1
2.2	a3	1
	b6	1
	c1	1
	d5	1
	e2	1
2.3	f4	1
	a6	1
	b5	1
	c2	1
	d3	1
	e1	1
2.4	f4	1
	a4	1
	b3	1
	c7	1
	d6	1
	e2	1
	f1	1